

Төрийн албаны зөвлөлийн
2019 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн
149 дугаар тогтоодын 20 дугаар хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг
баталсан огноо:

Байгууллагын нэр:

Орхон аймгийн Эрүүл мэндийн газар

Нийгмийн эрүүл мэндийн төв

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Бэлгийн замаар дамжих халдварт, хүний
дархлал хомсдолын вирусийн халдварт
өвчний тандалт, сэргийлэлт хариуцсан
мэргэжилтэн

Дэс түшмэл, ТЗ-5

Ажлын цаг:

Ажлын байрны албан ёсны байршил:

Ажлын өдөр 8 цаг

Орхон аймаг, Баян-Өндөр сум, Зэст баг,
Хантайн гудамж-1 Нийгмийн эрүүл мэндийн
төвийн байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

Хэвийн

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Бэлгийн замаар дамжих халдварт, хүний дархлал хомсдолын вирусийн халдвараас
урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх арга хэмжээг орон нутгийн онцлогт тохируулан
төлөвлөн, зохион байгуулах, зонхилон тохиолдох гэдэсний халдварт өвчний голомтод
хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, тандалт судалгаа хийх, урьдчилан
сэргийлэх чиглэлээр мэдээлэл, сургалт сурталчилгааг хүн амд түгээж ажиллан ажлын
үр дүнг эрүүл мэндийн газрын даргын өмнө тайлагнана.

Албан тушаалын зорилт:

1. Бэлгийн замаар дамжих халдварт, хүний дархлал хомсдолын вирусийн халдварын талаар үе тэнгийн сургагч багш нараар дамжуулан өсвөр үеийнхний мэдлэг, хандлагыг нэмэгдүүлэх, сургалт зохион байгуулах, зорилтот бүлгийн хүн амд бэлгийн замаар дамжих халдварын эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулж, эмчлэн эрүүлжүүлэх
2. Зонхилон тохиолдох гэдэсний халдварт өвчин хоол хүнсээр дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, зөв дадал хэвшлийг эзэмшүүлэх чиглэлээр мэдээлэл, сурталчилгааг эрчимжүүлэн, сэжигтэй тохиолдол бурт тандалт судалгаа хийх, хариу арга хэмжээг төлөвлөн зохион байгуулж, салбарын байгууллагуудтай тогтмол мэдээлэл солилцон ажиллах
3. Эхээс урагт гурвалсан халдварт /тэмбүү/ дамжихаас сэргийлэх, жирэмсний хяналтыг эрчимжүүлэх, сургалт зохион байгуулах
- 4.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг, дүрэм журам, стандартыг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах - Х Шийдвэрлэх - Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1. Ерөнхий боловсролын сургуулиудын үе тэнгийн сургагч багш нараар дамжуулан өсвөр үеийнхэнд бэлгийн замаар дамжих халдварт, хүний дархлалын хомсдолын халдварын вирусээс сэргийлэх талаар мэдээ мэдээлэл түгээх. 2. Дэлхийн ДОХ-той тэмцэх өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах. 3. Бэлгийн замаар дамжих халдварт, хүний дархлалын хомсдолын халдварын вирус/ДОХ-ын идэвхитэй илрүүлгийн компанийт ажлыг зохион байгуулах. 4. Бэлгийн замаар дамжих халдварт, хүний дархлалын хомсдолын халдварын вирус/ДОХ-оос сэргийлэх чиглэлээр их дээд сургуулийн оюутнуудын дунд аян зохион байгуулах.	Сургалт зохион байгуулсан байна. Уйл ажиллагааны тайлан гарсан байна. Ажил зохион байгуулсан байна. Аян зохион байгуулж, тайлан гарсан байна.	Г Г Г Г
2 дугаар зорилтын хүрээнд	1. Бага насны хүүхдүүдэд "Эрүүл дадал хэвшлийг" төлөвшүүлэх, сургалт сурталчилгааг зохион байгуулах. 2.Өвчлөлийн улиралчилалыг угтуулан суулгальт халдварын хөдлөл зүйд тандалт хийх, хариу	Сургалт зохион байгуулагдсан байна. Төлөвлөгөө хэрэгжсэн байна.	Г Г



	<p>арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллах.</p> <p>3.Хүүхдийн байгууллагад шинээр ажилд орсон ажилтнуудад ХХДӨ-өөс сэргийлэх чиглэлээр мэдлэг олгох сургалт зохион байгуулах.</p> <p>4.Цусан суулга, сальмонеллоор өвчлөөд эдгэрэгсэд, нян тээгчдийг хяналтад авч эрүүлжүүлсэн байдалд үнэлгээ хийх</p> <p>5.Эрүүл мэндийн байгууллагуудын эмч нарыг цочмог суулгалтын халдварын голомтод хариу арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байдал, мэдээ мэдээллийн урсгалд мэргэжил арга зүйн зөвлөмж өгөх</p> <p>6. Нэг голомтод 2-оос дээш цусан суулгалтын тохиолдолд үед дээд шатны байгууллагад яаралтай мэдээлэх, хариу арга хэмжээг зохион байгуулах.</p>	<p>Сургалт суртачилгаа хийгдсэн байна.</p> <p>Үнэлгээ хийгдсэн байна.</p> <p>Голомтын арга хэмжээний тайлан нэгтгэгдсэн байна.</p> <p>Хариу арга хэмжээний тайлан гарсан байна.</p>	<p>Г</p> <p>Г</p> <p>Г</p> <p>Г</p>
3 дугаар зорилтын хүрээнд	<p>1.Жирэмсний хяналтын чанарыг сайжруулах салбар дундын хэлэлцүүлэг зохион байгуулах.</p> <p>2.Жирэмсний хугацаанд тэмбүүгийн хурдавчилсан оношлуураар 4 удаа илрүүлсэн байдалд хяналтад хийж, хэвшүүлэх арга хэмжээг зохион байгуулах.</p> <p>3.Төрөлхийн тэмбүүгийн тохиолдлуудад мэргэжлийн багийг хуралдуулж, холбогдох шийдвэр, арга хэмжээг авч хэрэгжүүлэх.</p> <p>4.Тэмбүүгийн хурдавчилсан оношлуураар анхан шатны нэгжүүдэд илрүүлэг зохион байгуулах үйл явцад ажлын байрны сургалт, дэмжлэгт хяналт хийх.</p>	<p>Хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.</p> <p>Үйл ажиллагаа хэвшсэн байна.</p> <p>Баг хуралдаж холбогдох арга хэмжээг авсан байна.</p> <p>Хяналт хийгдсэн байна.</p>	<p>Г</p> <p>Г</p> <p>Г</p> <p>Г</p>
4 дүгээр зорилтын хүрээнд	<p>1.Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтийг хангуулах, тайлан мэдээлэл бэлтгэх.</p> <p>2.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлэх.</p>	<p>Журмын хэрэгжилт хангагдсан байна.</p> <p>Хууль тогтоомжоор заасан чиг үүргийн хэрэгжилтийг хангасан байна</p>	<p>Г</p> 

	<p>3. Бодлогын баримт бичиг, тогтоол шийдвэр, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах.</p> <p>4. Архивын тухай хууль, албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, албан бичгийн стандартыг мөрдөж албан хэрэг хөтлөлтөд үүссэн баримт бичгийн бүрдүүлэлт эмх цэгцийг хариуцан хадгаламжийн нэгж бүрдүүлж архивт шилжүүлэх.</p> <p>5. Удирдлагын хуульд нийцсэн үүрэг даалгаврыг шуурхай гүйцэтгэж ажиллах, эргэн мэдээлэх.</p> <p>6. Төрийн албан хаагчийн үйл ажиллагаандaa баримтлах ёс зүйн хэм хэмжээ, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар гарсан бодлого шийдвэр, хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөж ажиллах.</p> <p>7. Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх.</p> <p>8. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, дүрэм, журам, стандартыг хэрэгжүүлэн ажиллах;</p> <p>9. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, тайлагнах.</p> <p>10. Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлэх, тайлагнах.</p>	<p>Бодлого, шийдвэр, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангасан байна.</p> <p>Албан хэрэг, архив хөтлөлт стандартын дагуу хөтлөгдеж, сайжирсан байна.</p> <p>Шуурхай хэрэгжүүлж, эргэн мэдээлсэн байна.</p> <p>Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг мөрдөж ажилласан байна.</p> <p>Хуулийн хугацаанд мэдүүлгийг үнэн, зөв гарган гаргасан байна.</p> <p>Хөдөлмөрлөх нөхцөл хангагдсан байна.</p> <p>Гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, тогтоосон хугацаанд тайлагнасан байна.</p>	<p>Г</p> <p>Г</p> <p>Г</p> <p>Г</p> <p>Г</p> <p>Г</p>
--	--	---	---



III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.
Мэргэжил	Нийгмийн эрүүл мэнд судлаач, эрүүл ахуйч
Мэргэшил	Төрийн албаны мэргэшүүлэх богино, дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн байх
Туршлага	Туслах түшмэлийн албан тушаалд 2-оос доошгүй жил ажилласан байх

Үр чадвар	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - судалгааны арга зүйн мэдлэгтэй байх; - албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах, боловсруулах, харьцуулалт хийх, нэгтгэж дүгнэх, санал, зөвлөмж боловсруулах; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - бусад
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> -хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулах; -өөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж чаддаг; - бүтээлч, санаачлагч, үр дүн, үр нөлөөг урьдчилан харах чадвартай байх; - төрийн албан хаагчийн ёс зүйн хэм, хэмжээг сахих; - ашиг сонирхлын зөрчлөөс ангид, шударга байх; - хуулийн эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө өгөх чадвартай байх; - бүтээлч, санаачлагатай ажиллах; - бусад.
	Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> - өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонгой хуваалцаж, хамтран ажиллах; - багийн хамт олны дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх; - багийн зорилго, үйл ажиллагааг ойлгох, хүрээлэлд дасан зохицох, үр бүтээмжтэй ажиллах; - мэдлэг туршлага ур чадвараа бусадтай хуваалцах; - хамт олны зэрэг, нээлттэй уур амьсгалыг дэмждэг байх; - бусад.
	Бусад	<ul style="list-style-type: none"> - албан ажлын чиг үүргийнхээ дагуу зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх; - компьютерийн хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэд технологи ашиглах чадвартай байх; - төрийн албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг, монгол хэл, найруулгын чадвартай байх; -англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:

- 1.Эрүүл мэндийн газрын дарга
- 2.Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга

Албан тушаалд шууд харьялан
удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Байхгүй.

Бусад харилцах субъект :

- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба болон аймаг, сумын Засаг даргын Тамгын газрын холбогдох албан тушаалтан

- Эрүүл мэндийн яам, агентлаг, Олон улсын байгууллага



- Эрүүл мэндийн салбар байгууллагууд;

- Төрийн болон төрийн бус байгууллагууд;

- Иргэн, хуулийн этгээд.



V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

<u>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</u> <u>Албан тушаал:</u> ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНЫ НИЙГМИЙН АСУУДАЛ, ШАГНАЛ УРАМШУУЛАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН  С.МӨНХЗУЛ (Гарын үсэг) (Эцэг/эх-/ийн нэр, өөрийн нэр) 2019 оны 10 дугаар сарын 23 -ны өдөр	<u>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</u> <u>Байгууллагын нэр:</u> ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ <u>Шийдвэрийн огноо:</u> 19 10 23 <u>Дугаар:</u> 149
Албан тушаалын тодорхойлолтыг баталсан: <u>Байгууллагын нэр:</u> ОРХОН АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР <u>Шийдвэрийн огноо:</u> 2019-11.04 <u>Дугаар:</u> A/76 (тамга/тэмдэг) ДАРГА  Ц.МӨНХЦЭЦЭГ. (Гарын үсэг) (Эцэг/эх-/ийн нэр, өөрийн нэр) 2019 оны 11 дугаар сарын 04 -ны өдөр	
	